



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 1/04

Амардалай

Залуучуудын хөгжлийг дэмжих салбар
зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.2, Засгийн газрын 2019 оны 171 дүгээр тогтоолоор батлагдсан Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөрийн 5.2.8, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4.5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутагт залуучуудын хөгжил, оролцоог нэмэгдүүлэх, эрхийг хангах, салбар хоорондын хамтын ажиллагаа, идэвх санаачилгыг дэмжин ажиллах залуучуудын салбар зөвлөлийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг салбар зөвлөлийн гишүүд, нийгмийн бодлогын мэргэжилтэнд, үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар ханган, дэмжин ажиллахыг Багийн Засаг дарга нар, байгууллага, аж ахуй нэгжийн удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.

3.Залуучуудын идэвх санаачилгаар явуулж байгаа ашгийн төлөө бус нийтэд тустай үйл ажиллагааг дэмжих зорилгоор Залуучуудын өдрийг сар бүрийн 3 дахь 7 хоногийн Баасан гаригт зохион байгуулахаар зарласугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Сумын Засаг даргын 2021 оны А/73, А/116 тоот захирамжуудыг хүчингүй болгосонд тооцсугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, танилцуулж ажиллахыг Засаг даргын орлогч (Л.Золжаргал)-д даалгасугай.

ДАРГА

М.БАЯРСҮХ